



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 8/55

Шивээговь сум

**Ц.Замбагатай байгуулсан хөдөлмөрийн
гэрээг цуцлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 110 дугаар зүйлийн 110.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.1, 2.8.1 дэхь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Цэндпүрэвийн Замбага өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул хөдөлмөрийн гэрээг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс цуцалсугай.

2.Ц.Замбагын хариуцаж байсан ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Л.Цэнд-Аюуш

(Нягтлан бодогч)

Гишүүд:

Б.Ууганбаяр

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Б.Алтжин

(Нярав)

3.Ажлыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Л.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4.Ц.Замбагад ажилласан хугацааны мөнгийг бодож олгохыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЦЭРЭНДОРЖ



422220205